



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

[2021](#) оны [11](#) сарын [12](#) өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

ИРЭЭДҮЙН ӨВ САНГИЙН 2022 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2022 оны төсвийн жилд Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7.1-д заасан эх үүсвэрээс Монгол Улсын 0-18 хүртэлх насны иргэн бүрд Төрийн санд хуримтлагдах мөнгөн хуримтлалын хэмжээг сар бүр 100,000 /нэг зуун мянга/ төгрөгөөр тооцох бөгөөд 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл 100,000 /нэг зуун мянга/ төгрөгийг сар бүр мөнгөн хэлбэрээр, 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаанд 50,000 /тавин мянга/ төгрөгийг сар бүр мөнгөн хэлбэрээр тус тус олгож болно.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР